



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ

Дундговь аймаг

Зооноз өвчин судлалын төв нь Дундговь аймгийн хэмжээнд Байгалийн голомтот халдварт өвчин болон олон улсын хөл хориот өвчнүүд, шинэ сэргэн тархаж буй халдварт өвчний нийгэм биологийн хүчин зүйлийг судлах, амьтдын эпизоотын төлөв байдал өвчний эх уурхайг тогтоох, халдварын идэвхийг бууруулах, урьдчилэх сэргийлэх, лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлэх, хүний өвчлөлийн тохиолдол, дэгдэлтийн үед эрт сэрэмжлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллага юм.

Түүхэн замнал

Бүтэц, зохион
байгуулалт

Хамт олон

Алсын хараа
Эрхэм зорилго

Үйл ажиллагаа

ХАЯГ:

Дундговь аймаг, Сайнцагаан
сум, 7-р баг

Утас: 7059-2521

Email: du_gots@yahoo.com

Facebook: [дундговь з.ө.с.төв](#)

Түүхэн замнал



Анхны барилга 1997-2003 онд ашиглагдаж байв.



Одоогийн байр

1991 оны 7 сарын 15 -наас Өмнөговь аймгийн БГХӨСГ-аас тусгаарлан Дундговь аймгийн ЭАХС-ын хяналтын газрын харьяанд гоц халдвартын тасаг байгуулагдаж тус тасаг нь 1991-1993 онд Өмнөговь аймгийн БГХӨСГ-тай аймгийн нутагт тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээ, судалгаа, тандалтыг хамтран хийж байв.

1994 онд аймгийн Халдварт өвчин судлалын төвийн нэг тасаг болж бэлтгэмэлчин, биологичийн орон тоо шинээр нэмэгдсэн .

1997 онд аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэсийн даргын тушаалаар Байгалийн голомтот халдварт өвчин судлалын алба болон өргөжиж нийгмийн бодлогын хэлтэсийн харьяанд 8 хүний орон тоотой аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна .

2004 оноос ЭМГ-ын харьяанд шилжиж БГХӨТТ, 2012 онд БГХӨСА, 2013 оноос Зооноз өвчин судлалын төв нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

1997-2004 онд /1986 онд ашиглалтанд орсон / сувилалын зориулалтаар баригдсан 8 өрөө тасалгаатай байранд үйл ажиллагааг явуулж байсан.

2005 оноос аймгийн ИТХ-ын шийдвэрээр төрийн өмчийн мэдэлд байсан хуучин хүүхдийн номын сангийн барилгыг худалдан авч 10 сая төгрөгний төсвийн хөрөнгө оруулалтаар их засвар хийж , 2009 онд төсвийн хөрөнгө оруулалтаар 15 сая төгрөгний лабораторийн өргөтгөлийг хийж төвлөрсөн халаалтанд холбогдон, цэвэр бохир усны асуудлыг шийдвэрлэсэн.

Үе үеийн удирдлагууд :



Д.Тагирваа
/1991-1994 он/



Ч.Бямбаа
/1994-2003 он/



Д.Цэцгээ
/2004-2013 он/



Д.Алтантөгс
/2013 оноос/


Алсын хараа

Эрсдэлгүй орчин –Эрүүл мэнд

Эрхэм зорилго

Байгалийн голомтот, шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчнөөс хүн амыг урьдчилан сэргийлэх, лабораторит суурилсан тандалт судалгааг эрчимжүүлэх, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний зөв бодлого зохицуулалтаар хангаж нийгмийн эрүүл мэндийн тусламжийг сайжруулах.

Бүтэц, зохион байгуулалт



Байгууллагын чиг үүрэг

Аймгийн хэмжээний Байгалийн голомтот зоонозын халдварт өвчнийг тандан судлах, шинжлэх, оношлох, байгалийн голомтын төлөв байдлыг тогтоох, хүний өвчлөлийн тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулах, голомтот нутгийн болон эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулалтанд хамруулах, зоонозын өвчний талаар хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үндсэн чиг үүрэгтэй ажилладаг.

Манай байгууллага нь аймгийн эрүүл мэндийн газрын харьяанд, 8 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

Хамт олон





Үйл ажиллагааны зурагт агшин









